

Батлав. БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН БУЙ
ОРЧНЫ БОДЛОГО ҮНЭЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА /...../

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

ХОС ХӨЛӨГ ХХК-ийн захирал Д.МАНДАЛМАА



**2026 ОНД ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМАНД ХЭРЭГЖИХ “ТӨМӨР
ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ ТЕРМИНАЛ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 5353017

Хянасан: БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН
БУЙ ОРЧНЫ БОДЛОГО ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН
/...../

Боловсруулсан:

ХОС ХӨЛӨГ ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн Б.Нарантуяа

2026 он

ДЭД БҮТЦИЙН ТӨСЛИЙН ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГА

1. Төслийн товч танилцуулга

“Хос хөлөг” ХХК нь “Чойрложистик” ХХК-ийн 100 хувийн хувьцаа эзэмшигч бөгөөд менежментийн гэрээний дагуу “Төмөр замын ачиж буулгах терминал” төслийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулдаг ба Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг дэвсгэрт Засаг даргын 2015 оны 04 дүгээр сарын 13-ний өдрийн А/114 тоот шийдвэрийн дагуу Сүмбэр сумын 1-р баг Төмөр замын баруун талд 180000 м² газрыг 13 жилийн хугацаатай үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмшихээр гэрчилгээ авсан байна.

Эзэмшил талбайд “Хос хөлөг” ХХК нь захиргаа удирдлагын байр /оффис, цайны газар, ажилчдын амрах байр, харуул хамгаалалтын байр болон талбайн үйл ажиллагаа хангах гүний худаг, бетон хашаа зэргийг барьж байгуулсан.

Ачилт буулгалтын талбай нь жилд 1 сая тонн нунтаг ачаа ачиж буулгах хүчин чадалтай бөгөөд нийт 18,2 га талбайн 12 болон 6 га талбайд нэг дор 100 вагонд ачилт буулгалт хийх юм. Энэ зорилгоор төслийн талбайд 2,4 км төмөр замтай, 150 тн авто болон вагон пүүтэй, 24 цагийн харуул хамгаалалттай, гааль болон МХГ зэрэг төр захиргааны ажилчдын оффисын барилга

2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт орших “Хос хөлөг” ХХК-ийн “Төмөр замын ачиж буулгах терминал” төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан нь БОАЖЯ-аас боловсруулсан Ерөнхий үнэлгээний дүгнэлтэд үндэслэсэн бөгөөд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд хийгдсэн судалгаа, үнэлгээний ажлаас дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Тус “Хос хөлөг” ХХК нь Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт орших “Төмөр замын ачиж буулгах терминал” төслийг хэрэгжүүлэхдээ, байгаль орчны экологийн горимыг алдагдуулахгүй байх, ногоон байгууламжийн ажлыг зохих түвшинд чанартай гүйцэтгэж, төслийн сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, мөн төслийн үйл ажиллагаандаа Монгол улсын холбогдох хууль, эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажилласан тохиолдолд төслийг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн эх үүсвэр болон нөлөөлөлд өртөгдөх байгаль орчин, нийгэм эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгийг “Магадлан жагсаах арга”-аар тодорхойлбол төслийн үйл ажиллагаанаас байгаль, нийгэм-эдийн засгийн бүрдэл хэсэгт хамгийн их нөлөөлөл үзүүлэх бүрдэл хэсэг нь агаарын чанар, хөрсөн бүрхэвч байна. Хамгийн их нөлөөлөл үзүүлж буй үйл ажиллагаа нь хуурай түүхий эдийг хадгалах, ачих, буулгах бөгөөд хийж гүйцэтгэх үеийн тоосжилт нь агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Гэхдээ энэхүү төмөр замын ачиж буулгах терминал нь төсөл хэрэгжүүлэгчийн оруулж ирж буй ачаа барааг зөөвөрлөхөд шууд бөгөөд урт хугацааны эерэг нөлөөтэй. Тухайлбал авто машинаар тээвэрлэснээс замын хөдөлгөөний эрчимд үзүүлэх сөрөг нөлөөлөл арилж байна.

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх шууд нөлөөлөл 16, шууд бус нөлөөлөл 4 байна. Нийт нөлөөллийн 7 - бага хүчтэй, 9 - дунд эрчимтэй, 4 - хүчтэй нөлөөлөлд хамрагдаж байгаа боловч нөлөөллийн эерэг, сөргөөр авч үзвэл бага эрчимтэй нөлөөллийн 1 – эерэг, 6 – сөрөг; дунд эрчимтэй нөлөөллийн 3 – эерэг, 6 – сөрөг бөгөөд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь шууд, дундаас урт хугацааны, дунд зэргийн эрчимтэй нөлөөлөл байгааг тогтоов.

4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжүүлэгч “Хос хөлөг” ХХК-ийн “Төмөр замын ачиж буулгах терминал” төслийн албан ёсны баримт бичиг бөгөөд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд

төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартыг нэгтгэн тусгалаа.

Төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүр хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай. Ингэхдээ үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгох хэрэгтэй. Төслийн болон түүний нөлөөллийн бүс дэх бүх сөрөг өөрчлөлтөд мониторинг хийж, үнэлгээ хийх шаардлагатай. Энэ төлөвлөгөө нь төсөл хэрэгжүүлэгч жил бүр байгаль орчин хамгаалах төлөвлөгөө боловсруулахад ашиглагдах юм.

5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
0	1	2	3	4	5	6	7	8	9
Ачиж буулгах талбайн гадаад болон дотоод тээвэр									
1.	Агаарын чанар	Нунтаг ачаа ачиж буулгах үеийн тоосжилт, орчны бохирдлыг бууруулах битүү орчинтой, туузан дамжуулга бүхий технологи нэвтрүүлэх		га	-	5 га	Дотоод зардлаар	2024-2025 он	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4885:2007 - MNS 3384:82 Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага
2.		Тээврийн хэрэгслийн кабины дотор талын битүүмжлэлийг сайжруулах, агаарын тоосжилт хэмжигч багаж суурилуулж, дотоод орчны агаарын чанарыг тогтмол хянаж байх		Техникийн тоо	60,000	5 техник	300,000	Тогтмол	
3.		Төсөлд хорт хий бага ялгаруулдаг сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий машин механизм, техник хэрэгслийг барилгын талбайд ажиллуулах		Техникийн тоо	-	-	Дотоод зардлаар	Тогтмол	
Ачиж буулгах талбайн гадаад болон дотоод тээвэр									
4.	Ачиж буулгах талбай	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах, ажилтнууд тоос, шороо, элдэв төрлийн хийн бодисоос хамгаалах маск зүүх, зориулалтын ажлын хувцас хэрэглэлтэй байх	хүн	-	5		Дотоод зардлаар	2 жилд 1 удаа	Хөдөлмөрийн тухай хууль
5.		Уушги, зүрх судасны чиглэлээр эмчийн үзлэгт тогтмол хамруулж байх.	хүн		100,000	10	1000,000	Жилд 1 удаа	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4885:2007 - MNS 3384:82
6.		Төслийн үйл ажиллагааг цаг агаарын үзэгдэлтэй уялдуулан хийх, хүчтэй салхи, шуургатай үед гадаах ажлыг түр зогсоох		-	-	-	Хүчтэй салхи, шуургатай үед		

									Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага		
Агаарын чанарт тогтмол хянаж ажиллах											
7.	Агаарын чанар	Агаарын чанар, дуу шуугианы хяналт шинжилгээг тогтмол хийх, ОХШ-ний тэмдэглэл хөтөлж, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн, анхаарах аюултай тохиолдол бүрийг судалж шаардлагатай хариу арга хэмжээг авч ажиллана.	Төслийн нийт талбайн хэмжээнд	Улирал тутамд		-	-	-	Агаарын тухай хууль		
8.		Төслийн гол хэсгүүд, ажлын байр болон тогтоосон цэгт байнга тоосжилтын түвшний хэмжилт хийж байх ба хэрэв зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрвэл тэр даруй хяналтын арга хэмжээ авах	Төслийн нийт талбайн хэмжээнд	Тогтмол		-	-	-			
Гадаад болон дотоод тээвэрлэлтийн шороон зам											
9.	Хөрсөн бүрхэвч	Шороон замыг хайрган хучилттай болгох	Гадаад болон дотоод тээвэрлэлтийн шороон зам	км	5,000,000	1	2,000,000	1 удаа, гэхдээ тогтмол засаж сайжруулж байх	Байгаль орчны хамгаалал		
10.		Үйл ажиллагааны үед ажлын талбайн тоосыг бага байлгах үүднээс 2-4 л/м ² нормоор услах		М ²	-	-	Тогтмол				
11.	Ургамлын нөмрөг	Байгалийн унаган ургамлыг сэргээх ажлыг тухай бүр хэрэгжүүлэх		М ²	-		Дотоод зардлаар	2-3 улирал			
	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Усан орчны хяналт шинжилгээг тогтмол хийх		Төслийн нийт талбайн хэмжээнд	удаа	-	-	-		Жилд 2 удаа	Орчны хяналт шинжилгээг тухай бүрт хийлгэсэн байна. Зардлыг ОХШХ-т тусгав
	Усан орчинд үзүүлэх нөлөөллийг хянаж,	Төслийн бохир усны найрлагад тавигдах шаардлага, стандартын		Төслийн нийт талбайн хэмжээнд	удаа	200,000	1	200,000		Тогтмол	

	шаардлагатай арга хэмжээг тухай бүрт төлөвлөн хэрэгжүүлэх замаар сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.	дагуу холбогдох элемент бүрээр усны найрлагад хяналт тавих							
		Барилга, байгууламжийн ус зайлуулах байгууламжийн төлөвлөлт нь гадаргын урсцад нөлөөлөхгүй байхаар хийх	Төслийн талбайн хэмжээнд нийт	-				Тухай бүр	Усны тухай хууль БОАЖ, ЭМСайдын 2009 оны 51/75 дугаар тушаал MNS 900:2005 MNS 4943:2011 MNS 5850:2008
		Эдэлбэр газар дахь түр зуурын урсац өнгөрсний дараа ус нэвтрүүлэх хоолойн байгууламж дахь хурдсыг зайлуулж байх	Төслийн талбайн хэмжээнд нийт	-	90,000	1	90,000	Зуны улиралд хүчтэй бороо орсны дараа	
		Худгийг хууль эрхзүйн баримт бичигт заасан шаардлагад нийцсэн барилга, байгууламжаар тоноглох	Төслийн талбайн хэмжээнд нийт		750,000	1	550,000	2024-2027	
	Газрын доорхи усны нөөц	Технологийн хэрэгцээнд ашигласан усыг цэвэршүүлэн саармагжуулах	Төслийн талбайн хэмжээнд нийт		400,000	1	200,000	тогтмол	Технологийн хэрэгцээнд ашигласан усны химийн найрлагын тогтмол бүртгэл
		Үйлдвэрлэлийн аль ч үе шатанд цэвэрлээгүй бохир усыг байгаль орчинд хаяхгүй байх арга хэмжээг зохион байгуулж ажиллах	Төслийн талбайн хэмжээнд нийт					Тогтмол	
	Усыг их хэмжээгээр ашиглаж, усан орчинд сөрөг нөлөө үзүүлэх	Унд ахуйн хэрэглээнд ашиглах усыг арвилан хэмнэх	Төслийн талбайд					тогтмол	Унд ахуйн хэрэглээнд ашиглах усыг арвилан хэмнэж, усны нөөцийг гамтай хэрэглэж хэвшсэн байна.
		Жил бүр ус ашиглах дүгнэлтийг холбогдох мэргэжлийн байгууллагаар гаргуулж, усны нөөц, чанарыг хамгаалах чиглэлээр мэргэжлийн	Төслийн талбайд					тогтмол	

		байгууллагын өгсөн зөвлөмжийн дагуу тухай бүрт арга хэмжээ төлөвлөн гүйцэтгэнэ.							
		Усны алдагдлыг илрүүлэх зорилгоор усны балансын хяналт хийж байх	Төслийн нийт талбайн хэмжээнд		100,000	1	100,000	Тогтмол	
Нийт мөнгөн дүн							4,400,000		

6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
	Техникийн нөхөн сэргээлт. Нүүрснээс орчинд үзүүлэх нөлөөлөл	Нунтаг ачаа хураах задгай талбайг бетондож, нүүрс орчинд тархахгүй байхаар бетон хашилт хийх	Уурын зуухны нүүрс түр хадгалах задгай агуулах	Метр	-	-	Дотоод зардлаар	Эхний 2 жилд гүйцэтгэж, цаашид тогтмол засах	
	Ачаа тээвэрлэх, түгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаа шаардлагын дагуу зөв явагдаагүйгээс хөрс бохирдуулах	Нунтаг ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийг тогтоосон маршрутаар явуулах	Төслийн нийт талбайн хэмжээнд	-	-	-	-	Тогтмол	Тээврийн хэрэгслийг тогтоосон маршрутаар явуулна.
		Агуулах, ил задгай талбайн шалыг бетондох, үерийн хамгаалалт, даланг инженерийн нарийвчилсан үндэслэл тооцоотой хийж өгөх.	Агуулах	М ²	-	-	-	Тогтмол	Зардал нь дээр тусгагдсан
		Хөрс, болон усан орчин бохирдсон тохиолдолд бохирдлын тархалт нэмэгдэхээс сэргийлэх	Төслийн нийт талбайн хэмжээнд		-	-	-	Ослын үед	-
1.		Ногоон зурвас байгуулах	Төслийн талбайд	М ²	407700	2	815400	Тогтмол	-

2.	Биологийн нөхөн сэргээлт. Нүүрснээс орчинд үзүүлэх нөлөөлөл	Нийтийн эзэмшлийн талбайд тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих	Оршуулгын газар Зам дагуу хамгаалалтын ойн зурвас	га	8000	3000	3900000	Тогтмол	
Нийт дүн							4,715,400.0		

7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Археологийн дурсгал	Археологийн дурсгал илэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, орно нутгийн болон төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах	Тухайн төслийн талбайн хэмжээнд		Дотоод зардлаар	Дотоод зардлаар	Жилдээ	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
2.	Палеонтологийн дурсгал	Палеонтологийн дурсгал илэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, орно нутгийн болон төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах			Дотоод зардлаар	Дотоод зардлаар	Жилдээ	
	Нийт							

8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн хог хаягдал.	Ахуйн хог хаягдлаас хөрсний бохирдол бий болохоос урьдчилан сэргийлэх, Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг жил бүр боловсруулан хэрэгжүүлэх, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж ажиллах ба төслийн хог хаягдлын улмаас хөрсөн орчин бохирдохгүй байх арга хэмжээг авч ажиллах	Төслийн нийт талбайн хэмжээнд		-			Тогтмол	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсэгт төсөв тусгав.
2.		Бүх төрлийн шингэн хаягдал хаях цэгийг хөрсөнд үл нэвчүүлэх материалаар (шавар, элс) зузаан доторлож, хальж асгарахаас сэргийлэх	Төслийн нийт талбайн хэмжээнд		-			Тогтмол	
3.		Ажилчид, суурин дахь захиргаа-үйлчилгээний ажилчдын зорчих явган хүний зам, талбайг зориулалтын хайрган хучилттай болгох	Төслийн нийт талбайн хэмжээнд		-			-	MNS 5973 : 2009
4.	Үйлдвэрийн хог хаягдал	Техникийн засвар үйлчилгээний талбайг усны урсгал орохоос хамгаалагдсан талбайд ургамлын үеэс нь цэвэрлэж, бороо үерийн ус орохоос сэргийлсэн далан байгуулах	Төслийн талбайд	М ³	32,700	1	32,700	Тогтмол	ШТМ, түүний хаягдал алдагдах нөхцөлд тархалтыг хязгаарлах боломжтой байх / 1520,2 м ³ /
5.	Аюултай хог хаягдал	Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл,	Төслийн нийт талбайн хэмжээнд		-			Тогтмол	Байгууллагын дотоод журамд

		эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх							тусган хэрэгжүүлэх
6.		Хөрсөн орчны хяналт шинжилгээг тогтмол хийх						Жилд 1 удаа	Орчны хяналт шинжилгээг тухай бүрт хийлгэсэн байна. Зардлыг ОХШХ-т тусгав.
7.	Хөрсөн орчинд үзүүлэх нөлөөлөл ямар байгааг хянаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүрт төлөвлөн хэрэгжүүлж сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх хэрэгтэй	Газрын эвдрэлийг аль болох бага хэмжээнд байлгах талаар анхаарч, үйл ажиллагааг нарийн төлөвлөх, шаардлагагүй тохиолдолд шинээр газар хөндөхгүй байх	Төслийн нийт талбайн хэмжээнд					Төслийн хүрээнд	
8.		Түүхий эд хадгалах талбайг тэлэх үед ажил эхлэхийн өмнө нөлөөлөлд өртөөгүй талбайн өнгөн хөрсийг “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт MNS 5617:2008”-д заасны дагуу хуулж, хадгалж нөхөн сэргээлтэд ашиглах			70,000	1	70,000	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө хуулсан шимт хөрс	MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
9.		Хөрсний бохирдлоос хамгаалах зорилгоор бүх ажилчдад үйлдвэрийн болон ахуйн хэрэглээний аюултай материал (химийн бодис, шатамхай хий, тэсрэх бодис, шатах, тослох материал)-тай харьцах асуудлаар цогц сургалт, зааварчилгаа явуулах			150,000	1	150,000	Улиралд 1 удаа	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм
10.		Шатах тослох материалын хадгалалт, ашиглалтад байнгын хяналт тавьж ажиллана.						Тогтмол	
		Нийт, төгрөг				252,700.0			

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		1	2	3	4	5	6	7	8
2	Ахуйн	Ахуйн хатуу хог хаягдлыг ангилан цуглуулах, хог хаягдлыг түр хадгалах цэг байгуулах	Төслийн талбайд	ширхэг	350,000	1	350,000	тогтмол	Төслийн талбай орчимд салхины чигийн доод талд ахуйн хатуу хог хаягдлыг ангилан цуглуулах бетонжуулсан хог хаягдлыг түр хадгалах цэг байгуулсан байна.
3	Ахуйн	Хог хаягдлын цэгийг тогтмол ариутгаж байх	Төслийн талбайд	удаа	40,000	1	40,000	улирал бүр	Хог хаягдлын цэгийг улирал бүр тогтмол ариутгана.
4	Ахуйн	Ахуйн аюултай хог хаягдал болон сав баглаа боодлыг Төслийн талбайд тусгай контейнерт хадгалах	Төслийн талбайд	удаа	40,000	1	40,000	тогтмол	Ахуйн аюултай хог хаягдал болон химийн бодисын сав баглаа боодлыг Төслийн талбайд тусгай контейнерт хадгална.
5	Ахуйн	Дахин боловсруулах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгүүдэд нийлүүлэх	Төслийн талбайд	удаа	50,000	1	50,000	тогтмол	Дахин боловсруулах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгүүдэд тээвэрлэн бүхүргэнэ.
6	Ахуйн	Ахуйн бохир ус зайлуулах цэгийг стандартын дагуу байгуулах	Төслийн талбайд	удаа	1,000,000	1	1,000,000	тогтмол	M7NS 6230 : 2010
7	Ахуйн	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ сумын ТҮК-тэй гэрээ байгуулах	Төслийн талбайд	удаа	Дотоод зардлаар	-	-	Жил бүр	Гэр8ээт хугацаанд хог хаягдлын зайлуулж байх, MNS 5344:2011
8	Ахуйн	Ажилчдад өөрсдийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдал, түүнийг хэрхэн ангилан ялгах,	Төслийн талбайд		Дотоод зардлаар			Жилд 2 удаа	Хог хаягдлын тухай хууль

		боломжтойг дахин ашиглах талаар сургалт явуулах							
9	Ахуйн	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	Төслийн талбайд		Дотоод зардлаар			2024-2025	Хог хаягдлын тухай хууль
10	Ахуйн	Хуванцар сав, шил, лааз гэх мэт хаягдлыг 2-догч түүхий эд авах цэгт тушаах	Төслийн талбайд	кг	72,000	1	72,000	Сард 1 удаа	Хог хаягдлын тухай хууль
11	Ахуйн	Аюултай хог хаягдал үлдэгдлийг үйлдвэрлэлийн хаягдал материал устгахад орон нутгийн мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл дүгнэлтийн дагуу мэргэшсэн мэргэжлийн байгууллагаар устгуулах	Төслийн талбайд	-	-	-	-	тогтмол	Хог хаягдлын тухай хууль
12	Ахуйн	Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах	Төслийн талбайд	-	-	-	-	Тухай бүрт нь	
13	Ахуйн	Хог хаягдлыг ил задгай, зориулалтын зуухнаас бусад байдлаар шатаахыг хориглоно.	Төслийн талбайд	-	-	-	-	-	Хог хаягдлын тухай хууль

14	Ахуйн	Боломжтой хог хаягдлыг дахин ашиглах, ажилласан тос тосолгоо, шатах тослох материалыг тусгайлан битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан төслийн талбайд хадгалах	Төслийн талбайд	-	-	-	-	Тухай бүрт нь	
15	Ахуйн	Ажилчдад өөрсдийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдал, түүнийг хэрхэн ангилан ялгах, боломжтойг дахин ашиглах талаар сургалт явуулах	Төслийн талбайд	улиралд	-	-	-	Жилд 2 удаа	
16	Ахуйн	Ажилласан тос тосолгоо, шатах тослох материалыг дахин боловсруулах үйлдвэрт гэрээний дагуу нийлүүлж байх	Төслийн талбайд	-	-	-	-	Тогтмол	“Алтан Оршихуй Групп” ХХК -ний “Ахуй Сайхан” (монгол улсын анхны аюултай хог хаягдал дахин боловсруулах тусгай зөвшөөрөлтэй) ажилласан тос масло дахин боловсруулах үйлдвэр эрхэлдэг.
17		Хог хаягдал ангилан ялгах стандартыг Засгийн газрын тогтоолд тулгуурлан боловсруулан мөрдүүлэх	Төслийн талбайд	-	-	-	-	Тогтмол	Хог хаягдал ангилан ялгах дотоод стандарт
18	Аюултай	Аюултай хог хаягдлыг түр хадгалах байртай болох	Төслийн талбайд	-	-	-	-	Тогтмол	Аюултай хог хаягдлын холбогдох хууль журам

		Холбогдох байгууллагатай гэрээ байгуулж тээвэрлэх, шилжүүлэх, бүртгэл хөтлөх, хяналт тавих	Төслийн талбайд	-	-	-	-	Тогтмол	Аюултай хог хаягдлын холбогдох хууль журам
	Нийт						1,552,000.0		

9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ачиж буулгах үйл ажиллагаа (ашиглах, хадгалах) явуулж байгаа газруудын барилга, байгууламжийн инженерийн төлөвлөлтийг хүчтэй салхи болон үерийн аюулд өртөхгүй байдлаар хийх	Төслийн талбайд		-		-	тогтмол	Аюул осолгүй үйл ажиллагаа
2	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрмийг сахих, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах хяналт байнга тавих			-		-	Тогтмол	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрмийг сахих, осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах хяналт байнга тавьж ажиллана.
4	Гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар ажилчдын дунд сургалт явуулах			100,000		100,000	жил бүр	Гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар ажиллагсдын дунд жил бүр 1 удаа сургалт явуулна.
5	Ажлын байранд гал гаргахыг хатуу хориглосон анхааруулга тэмдгийг үзэгдэхүйц газар байрлуулах			150,000		150,000	тогтмол	Анхааруулга тэмдгийг үзэгдэхүйц газар байрлуулна.
6	Гал хорны ажиллагааг тогтмол шалгаж тэмдэглэл хөтөлж байх			-		-	Тогтмол	Гал хорны ажиллагааг тогтмол шалгаж тэмдэглэл хөтөлж байна.
7	Нэг бүрийг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр (ажлын хувцас, өвөл, зуны гутал, хамгаалалтай нүдний			-		-	жилд 2 удаа	Учирч болзошгүй гал түймрийн ослоос сэргийлж ажилчдыг

	шил, бээлий, чих бөглөгч г.м) хангах							ажлын хувцас, багаж хэрэгслээр жилд 2 удаа шинээр хангана. /Байгууллагын дотоод зардлаар/
8	Ажилчдад ослын үед цаг алдалгүй анхны тусламж үзүүлэх зорилготой анхны тусламж үзүүлэх эмийн сан байрлуулж тогтмол дүүргэж байх							Анхны тусламж үзүүлэх эмийн сан байрлуулсан байна.
9	Аянга зайлуулагч байрлуулах			300,000		300,000	тогтмол	Төслийн байр, агуулахад аянга зайлуулагч байгуулах
10	Болзошгүй осол эндэгдэл гаргах, хүний амь насанд аюул учруулж болох нөхцөлөөс урьдчилан сэргийлэх			-		-	Тогтмол	Болзошгүй осол эндэгдэл гаргах, хүний амь насанд аюул учруулж болох нөхцөлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй ажиллана.
11	Ослын үед ажиллах ИТА-ын үйл ажиллагааны төлөвлөгөө хийж нийтэд танилцуулах			-		-	Тогтмол	Ослын үед ажиллах ИТА- ын үйл ажиллагааны төлөвлөгөө хийж нийтэд танилцуулж хэрэгжүүлнэ.
12	Ажилчдыг ослын үед өөртөө болон бусдад үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламжийн арга барилд сургах арга хэмжээ			-		-	Тогтмол	Ослын үед өөртөө болон бусдад үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламжийн сургалт, арга хэмжээ
13	Ослын шалтгааныг тогтоох, дахин осол гаргахаас сэргийлэх, хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах			200,000		200,000	Тогтмол	Осол гарсан үед ослын шалтгааныг тогтоох, дахин осол гаргахаас сэргийлэх, хяналтын байгууллагуудтай хамтран ажиллана.
14	Ажилчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар мэдлэг олгох сургалтад тогтмол хамруулж байх, биелэлтэд хяналт тавих			-		-	Тогтмол	Хүний нөөцийн албанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар мэдлэг олгох сургалтын хэрэгцээг тодорхойлж сурталтанд хамруулсан байх

15	Ажилд авахад ажилчдыг эмнэлгийн үзлэгт оруулж, эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэхийг тодорхойлсон байх			-		-	Тогтмол	Ажилчдын эрүүл мэндийн байдал, хөдөлмөр аюулгүй ажиллагааны жил бүрийн тайлан мэдээ
16	Ажлын байрны аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, плакат, тэмдэг өлгөх зэрэг зайлшгүй арга хэмжээнүүдийг авч хяналт тавьж байх						Тогтмол	Ажлын байрны аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн тухай жил бүрийн тайлан
17	ХХАА - ы дүрэм заавар дотоод журмыг боловсруулах, танилцуулах, сургалт зохион байгуулах			-		-	Тогтмол	ХХАА - ы дүрэм заавар дотоод журам боловсруулж сургалт зохион байгуулсан байна
18	Үйлдвэрийн харуул хамгаалалтыг сайжруулж бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх			--			Тогтмол	Осол аюулгүй үйл ажиллагаа
	Нийт зардал					750,000.0		

10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайл бар	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
Агаарын сорьц шинжилгээ								
1	Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо CO ₂ NO ₂ 3SO ₂	Төслийн талбайд-6 цэг	Улирал бүр	4	262,500	1,050,000		MNS 4990:2015., MNS 4968:2000, MNS 4585:2016
2	Тоос (нийт, PM10, PM2.5)	Төслийн талбайд -9 цэг	Улирал бүр	4	262,5000	1,050,000	-	MNS 4990:2015., MNS 4968:2000, MNS 4585:2016
Хөрсний шинжилгээ								
3	Хөрсний хими физикийн шинж чанар, хүнд металлын / As, Cr, Cd, Cu, Pb, Ni, Fe, Zn/, нефть бүтээгдэхүүний бохирдол	Төслийн талбайд - 9 цэг	Намар 9 сард	1	450,000	450,000	-	MNS 5850 : 2019
Усны шинжилгээ								
4	Ундны усны бүрэн шинжилгээ	Гүний худаг 1, төслийн талбайн хэмжээнд 3	2 сард 1 удаа	6				
5	Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо Усны химийн найрлага: Гол ионууд: Ca, Cl, K, Mg, Na, SO ₄ , HCO ₃ , NH ₄ , CO ₃ , TDS, pH, NO ₃ , EC, tem total hardness, NO ₂ , ууссан хүчилтөрөгч BOD, TSS Ундны усан дахь хүнд металлын агууламж Металууд: Al, Cd, Cr, Cu, Fe, Mn, Mo, Pb, As, Co, Ba, Ni, Ag, V, Zn, Se, Si, B	Гүний худаг 1, төслийн талбайн хэмжээнд 3	2 сард 1 удаа	6	384,000	4,608,000	-	MNS 0900:2018. Ундны усны чанарын стандарт - MNS 4586:1998. Усан орчны чанарын үзүүлэлт - MNS 4943:2015 Хаягдал ус. Ерөнхий шаардлага
Хөдөлмөр Хамгаалал ба Эрүүл ахуйн хяналт								
6	Дуу шуугиан, ажилчдын болон суралцагсдын эрүүл мэндийн үзлэг		Улиралд 1 удаа	4	30,000	120,000		MNS 6768:2019
	Нийт					7,278,000.0		

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			Сар-4	Сар-8	Сар-12		
1	2	3	4	5	6	7	
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, энэ чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоох, БО-г хамгаалах асуудлаар байгууллагын ажилтан, ажилчин бүрийн хариуцах ажил, хүлээх үүргийг тогтоон өгч ажил үүргийн хуваарь, хөдөлмөрийн гэрээнд тусгаж хэрэгжүүлэх	Дотоод зардлаар				Хүний нөөц	
2	Төслийн хэмжээнд орон тооны байгаль орчны болон олон нийттэй хамтарч ажиллах ажилтан авч ажиллуулах	Дотоод зардлаар				Хүний нөөц	
3	Байгаль орчны төлөвлөгөөт аудитын зөвлөмж хэрэгжүүлэх					Салбарын эрхлэгч	-
4	Тоног төхөөрөмжийн урсгал болон ээлжит засварын ажлыг тогтмол графикийн дагуу хийж гүйцэтгэх	Дотоод зардлаар				Салбарын эрхлэгч	
5	БО-г хамгаалах чиглэлээр өөрийн ажилтан, ажилчдын дунд сургалт семинарыг улиралд нэг удаа тогтмол зохион байгуулах	50,000		50,000		Салбарын эрхлэгч	
6	Байгаль орчны болзошгүй нөлөөлөл, аюул ослын үед орон нутгийн цэрэг иргэний хамгаалалт, гал, хүн, мал эмнэлгийн байгууллагатай хамтран ажиллах хамтын төлөвлөгөөтэй байх, үүнд шаардлагатай техник хэрэгсэл бэлтгэх, шинэчлэх, мэдээлэл харилцан солилцож ажилтан, ажилчдад дадлага эзэмшүүлэх ажлыг жил бүр зохиож байх	871,300			871,300	Салбарын эрхлэгч	
7	Гал унтраах хэрэгслээр байгууллагыг бүрэн хангах арга хэмжээ авах, үйлдвэрлэлийн онцлогтой холбогдуулан галыг унтраах нэмэлт хэрэгсэл авах, галыг унтраах талаар тодорхой	Дотоод зардлаар				Нягтлан бодогч	

	түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах						
8	Төслийн ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж мөрдөх	-				Хүний нөөцийн ажилтан	
9	Орчны хяналт шинжилгээнд тусгасан ажлуудыг жил бүр мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар бүрэн хийж байна.	ОХШТ-тайланд тусгагдсан				Салбарын эхлэгч	
10	Газар, ус ашигласны төлбөр, хог хаягдлын төлбөрийг орон нутгийн төсвийн дансанд тухай бүрт хугацаа алдалгүй төлж байх	Дотоод зардлаар				Нягтлан бодогч	
11	Усны нөөцийн мэргэжлийн байгууллагаар усны нөөцийн судалгааны ажлыг гүйцэтгүүлэх	-				Салбарын эрхлэгч	
12	Нөлөөллийн бүсийг тогтоохдоо 10 км радиус дотор төслийн үйл ажиллагаанд хяналт тавих, төслийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шийдвэрлэж байх	Дотоод зардлаар				Салбарын эрхлэгч	
13	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын ажлын хувцас, багаж хэрэгслээр бүрэн хангах					Нягтлан бодогч	
14	Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагтай хамтран ажиллах, харилцан тохиролцож тэдний санал хүсэлтийг шийдвэрлэх, Тэрбум мод үндэсний хөдөлгөөнтэй хамтран ажиллах	1,000,000	1,000,000			Салбарын эрхлэгч	
15	Бүх ажилчдад байгаль хамгаалах талаар сургалт орох - Компанийн байгаль орчны талаар баримталж буй бодлого, хууль эрхзүй - Бидний үйл ажиллагаа БО-д хэрхэн нөлөөлдөг вэ? - БО-д ээлтэй байхын тулд би юу хийж чадах вэ? - Шатах тослох материалын асгаралт, түүнээс урьдчилан сэргийлэх тухай - Ахуйн болон аюултай хог хаягдлыг ангилан ялгах, тэмдэг тэмдэглэгээг таниулах, зөв дадал өгөхөд чиглэсэн сургалт явуулах	Дотоор зардлаар	-			Салбарын эрхлэгч	
16	Дотоод хяналтыг хэрэгжүүлэх	Дотоор зардлаар	-			Салбарын эрхлэгч	
	Нийт	1,921,300	1,000,000	50,000	871,300		

12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Сүмбэр сумын ИНХ	Сумын ИНХ-аар илтгэл тавьж, мэдээлэл өгөх	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл	Жилд 1 удаа	500,000	Салбар хариуцсан ажилтан	-
2	Засаг даргын Тамгын газар	Харьяа нутаг дэвсгэрийн Захиргаанд төслийн байгаль хамгааллын ажлын талаар мэдээлэл өгөх	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл	Жилд 1 удаа	500,000	Салбар хариуцсан ажилтан	-
3	БОУАӨЯ	БО-г хамгаалах ажлын жилийн тайлан, төлөвлөгөөгөө БОУАӨЯ-нд цаг тухайд нь гаргаж өгч байх	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл	Тогтмол	300,000	Салбар хариуцсан ажилтан	-
	Нийт				1,300,000.0		

2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ТӨСӨВ

№	Төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг	Нийт дүн
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	4,400,000.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	4,715,400.0
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	-
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	750,000.0
5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	1,804,700.0
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	7,278,000.0
7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	871,300.0
8	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	1,300,000.0
	БОМТ-ний нийт төсөв	21,159,400.0